



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Эмэгтэйчүүдийн уулзалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалт, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.9 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Олон Улсын эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан “Эмэгтэйчүүдийн эрх ба нийгэм дэх оролцоо” сэдэвт дүүргийн эмэгтэйчүүдийн уулзалт, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2015 оны 03 сарын 08-ны өдөр зохион байгуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 05-ны
өдрийн 20 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Эмэгтэйчүүдийн эрх ба нийгэм дэх оролцоо”
сэдэвт дүүргийн эмэгтэйчүүдийн уулзалтын
арга хэмжээний удирдамж

Зорилго: “Олон Улсын эмэгтэйчүүдийн өдөр”-ийг тохиолдуулан Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал, тэдний нийгэм дэх оролцоог хангахтай холбоотой тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн дүгнэх, өөрчлөлт шинэчлэлт, Төр, орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Зохион байгуулагч: Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс

Хугацаа: Арга хэмжээ 2015 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 11⁰⁰-14⁰⁰ цагийн хооронд зохион байгуулагдана.

Зохион байгуулах газар: Соёл Урлагийн Их Сургуулийн “Оюутан” театр

Хамрах хүрээ: Чингэлтэй дүүргийн 1-19 хорооны иргэд

Зохион байгуулалт: Хороо тус бүрээс эмэгтэйчүүдийн төлөөлөл 20 иргэн буюу нийт 380 иргэнийг оролцоно. Иргэний танхимын ажилтнууд арга хэмжээнд оролцох эмэгтэйчүүдийн төлөөллийн нэрсийн жагсаалтыг 2015 оны 03 дугаар сарын 5-ны дотор Иргэний оролцооны хэлтэст ирүүлэх бөгөөд батлагдсан нэрсийн дагуу иргэдийг товлосон хугацаанд бэлэн байлгах ажлыг хариуцна.

Үр дүн: Эмэгтэйчүүдийн эрх, нийгэм эдийн засгийн тэгш оролцооны талаарх мэдээллээр хангагдаж, Төрийн бодлого, үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэнэ.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 05-ны
өдрийн 20 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Эмэгтэйчүүдийн эрх ба нийгэм дэх оролцоо”
сэдэвт дүүргийн эмэгтэйчүүдийн
уулзалтын хөтөлбөр

Арга хэмжээ: 2015 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 11⁰⁰ цагт “СУИС”-ын
“Оюутан” театрт зохион байгуулагдана.

- | | |
|------------------------------------|--|
| 10 ⁵⁰ -11 ⁰⁰ | Бүртгэл |
| 11 ⁰⁰ -11 ¹⁰ | Нээлт /Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ/ |
| 11 ¹⁰ -11 ²⁰ | Чингэлтэй дүүргийн Засаг даргын мэндчилгээ. |
| 11 ²⁰ -12 ²⁰ | “Эмэгтэйчүүдийн эрх, нийгэм дэх байр суурь, хөгжилд гүйцэтгэх үүрэг” сэдэвт илтгэл

/“Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн, 2007-2011 оны эмэгтэйчүүдийн нэр төр, эрүүл мэндийн төлөөх Олон Улсын шагналтан, Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан Д.Мөнхөө/ |
| 12 ²⁰ -12 ⁵⁰ | “Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт илтгэл

/Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Ж.Чимэдцогзол/ |
| 12 ⁵⁰ -13 ⁵⁰ | Урлагийн тоглолт |
| 13 ⁵⁰ -14 ⁰⁰ | Хаалт |



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасугай.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Чандмань одонгоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, Хурлын Хүндэт өргөмжлөлөөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоолын нэг дүгээр хавсралт



“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэрэжлil	Регистрийн дугаар
1.	Ж.Шадар	Чингэлтэй дүүргийн 18 хорооны ахмад настан	
2.	Г.Дамба	Чингэлтэй дүүргийн 18 хорооны ахмад настан	ХВ37050177
3.	Ч.Отгонбаяр	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ44081504
4.	Р.Лувсансумъяа	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ46100211
5.	Д.Дүгэрсүрэн	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ43070104
6.	Г.Лхамаа	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ВЕ54121514
7.	Б.Сэлэнгэ	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ49051117
8.	Б.Цогзолмаа	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	Г369042602
9.	Т.Жавзмаа	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ЧК45091028
10.	Д.Пүрэвдорж	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ35070131
11.	Т.Марсаржав	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ПЮ39020171
12.	Д.Энх-Амгалан	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн тогоч	ВТ63010400
13.	Д.Цэвсүрэн	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ57070402
14.	Ч.Цэрэнлхам	Чингэлтэй дүүргийн 15 хорооны ахмад настан	ХЖ61041400
15.	Н.Оюунгэрэл	Чингэлтэй дүүргийн 15 хорооны олон нийтийн байцаагч	ОЛ68011960
16.	Б.Нарангэрэл	Чингэлтэй дүүргийн 16 хорооны иргэн	ХЖ59110701
17.	Д.Наранцэцэг	Чингэлтэй дүүргийн 16 хорооны иргэн	ХМ57102208
18.	Ч.Үдээхүү	Чингэлтэй дүүргийн 16 хорооны ахмад настан	ОС54021808

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 05-ны
өдрийн 21 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Г.Загарсүрэн	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ахмад настан	Х352071014
2.	Б.Палаанз	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ахмад настан	ХЙ26030116
3.	С.Нэргүй	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ахмад настан	Х347111003
4.	А.Баянжаргал	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодогч	ЧС84112606
5.	Д.Даваасүрэн	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны ахмад настан	ХД39011401
6.	Г.Гиваапилжээ	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны ахмад настан	УС55050809
7.	И.Сумъяа	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны ахмад настан	ХЖ54041607
8.	Д.Тогтохбаяр	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны ахмад настан	ЦИ45011801
9.	Б.Ундармаа	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны хэсгийн ахлагч	ХМ72032507
10.	П.Маруся	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ЦД56031965